

# Хувь хүний орлогын албан татварын хууль болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд орсон өөрчлөлтүүд

## Холбоо барих:

### Майкл Ахэрн

Партнер  
Татвар, Хуулийн  
зөвлөх үйлчилгээ  
[michael.ahern@pwc.com](mailto:michael.ahern@pwc.com)

### Чойжамцын Цэндмаа

Захирал  
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ  
[tsendmaa.choijamts@pwc.com](mailto:tsendmaa.choijamts@pwc.com)

### Мишигийн Мөнхтуяа

Менежер  
Санхүү, татварын тайлагналын  
үйлчилгээ  
[munkhtuya.mishig@pwc.com](mailto:munkhtuya.mishig@pwc.com)

### Жамбалын Энхзул

Менежер  
Татварын зөвлөх үйлчилгээ  
[enkhzul.jambal@pwc.com](mailto:enkhzul.jambal@pwc.com)

### ПрайсвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК

Сентрал Тауэр, 6 давхар  
601 тоот, Улаанбаатар  
14200, Монгол улс  
Утас : + 976 70009089  
Факс : +976 11 322068  
[www.pwc.com/mn](http://www.pwc.com/mn)

ХХОАТ болон НДШ-ийн талаар дэлгэрүүлэн тодруулах, эсхүл танд мэргэжлийн туслалцаа хэрэгтэй бол бидэнтэй холбогдоно уу.

Монгол Улсын Улсын Их Хурал нь Засгийн газрын өргөн барьсан 2023 оны Төсвийн тухай хуулийн төслийг дагалдах хуулийн төслүүдийн хамт 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хэлэлцэж баталсан бөгөөд үүнтэй холбоотойгоор Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийг та бүхэнд танилцуулж байна.

## Хувь хүний орлогын албан татварын (“ХХОАТ”) тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль:

Олон улсын нийтлэг туршлагад үндэслэн, орлогын тэгш бус байдлыг бууруулах зорилгоор 2023 оноос эхлэн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого болон шууд бус орлогод “шаталсан хувиар” ХХОАТ ногдуулахаар хуульчиллаа. Хуулийн өөрчлөлт нь цалин хөдөлмөрийн хөлсний орлого олж буй нийт иргэдийн 0.1 хувьд нөлөөлөхөөр байна гэж хуулийн төслийн танилцуулгад дурдсан байна



## Хэрхэн өөрчлөгдсөн вэ?

ХХОАТ-ын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого болон шууд бус орлогын жилийн татвар ногдуулах орлогын дүнд дараах хувь хэмжээгээр албан татвар ногдуулна:


Жилийн орлого (₮)	Татварын хэмжээ (%)
0 - 120 сая (сарын 0-10 сая)	10%
120 сая - 180 сая (сарын 10-15 сая)	12 сая төгрөг дээр нэмэх нь 120 сая төгрөгөөс дээш давсан орлогод 15%
180 сая төгрөгөөс дээш (сарын 15 сая төгрөгөөс дээш)	21 сая төгрөг дээр нэмэх нь 180 сая төгрөгөөс дээш давсан орлогод 20%

Жишээлбэл сарын 15 сая төгрөгийн цалин хөдөлмөрийн хөлсний татвар ногдуулах орлоготой хувь хүнээс дээрх шаталсан хувь хэмжээний дагуу сар бүр 1,750,000 төгрөгийн ХХОАТ-ыг ногдуулан суутгах бөгөөд татварын дундаж хувь хэмжээ нь 11.67% байна.

Мөн түүнчлэн хуулийн дагуу татвар суутгагч этгээд нь хувь хүнд олгосон цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого болон шууд бус орлогын татвар ногдуулалт, хөнгөлөлтийн тооцоог жилийн эцсийн тайлангаар эцэслэн тооцож тайлагнан, холбогдох татварыг төсөвт шилжүүлэхээр хуулийн нэмэлт өөрчлөлтөд нарийвчлан заасан байна.

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2022 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайсвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.



## ХХОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (үргэлжлэл):



### Хамрах хүрээ болон хүчин төгөлдөр болох өдөр

Энэхүү шинэчилсэн хувь хэмжээ нь зөвхөн байнга оршин суугч албан татвар төлөгчид хамаарах бөгөөд үүнд доор дурдсан нөхцөлийн аль нэгийг хангасан хувь хүнийг хамааруулна:


- үргэлжилсэн 12 сарын хугацаанд нийт 183 ба түүнээс дээш хоног Монгол Улсад оршин суусан;
- албан татвар ногдох орлогын 50 ба түүнээс дээш хувийг Монгол Улсад олсон орлого болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлого эзэлж байвал;

**Энэ хуулийн өөрчлөлтийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.**

Монгол Улсад оршин суугч бус татвар төлөгч нь Монгол улсад болон Монгол улсаас эх үүсвэртэй олсон орлогодоо 20% -ийн татвар төлдөг.



## Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай



Дээрх ХХОАТ-ын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөс гадна **2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс** эхлэн улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн доод хэмжээг нэг цагт 3,273 төгрөг 80 мөнгө буюу сард 550,000 төгрөг байхаар 2022 оны 05-р сарын 04-ний өдрийн Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 10 дугаар тогтоолын дагуу шинэчлэн тогтоосон билээ.

Үүнтэй холбогдуулан 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн сар бүрийн даатгуулагчаас суутгах нийгмийн даатгалын шимтгэлийн (НДШ) дээд хэмжээ 632,500 төгрөг болж өөрчлөгдөхөөр байна. Одоогоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 420,000 төгрөг ба даатгуулагчийн төлөх НДШ –ийн дээд хэмжээ нь 483,000 төгрөг байгаа юм.



Та дээрх сэдэв болон бусад асуудлаар зөвлөгөө авах бол бидэнтэй холбоо барина уу.

ХХОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах бол [энд дарна уу](#).

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоолын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах бол [энд дарна уу](#).

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2022 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайсвотэрхаусКүүперс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.